

АЛАНГУА ЭХИЙН ДОМОГ АРДЫН СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖ БОЛОХ НЬ

Ц.Баасандорж

Краткое заключение

Прежде всего мы полностью разделяем мнение о том, что “Легенда о матери Алан-гуа” Ц.Дамдинсурэна по своему происхождению является древней монгольской легендой, и подчёркиваем, что эта легенда служит источником монгольской народно-педагогической традиции.

По нашим наблюдениям в “Легенде о матери Алан-гуа” нашли отражение следующие три основных принципа и один метод, используемые в современной практике обучения: Во-первых, Алан-гуа использовала один из основных принципов современного обучения — принцип “Создания условий, соответствующих для ведения процесса обучения”. Во-вторых, она придерживалась принципа обучения Восточных народов, который гласит, что человек забывает услышанное, вспоминает, если показать, учиться, если сам проделывает, то есть придерживалась принципа обучения через действия, дав своим детям самим совершить действие. Таким образом учения матери Алан-гуа увековечились в памяти её сыновей и последующих поколений.

Ещё XVII веке великий педагог Я.А.Коменский отмечал крайне малоэффективность обучения посредством пустой проповеди, устной передачи информации и выдвигал идею его замены обучением посредством наглядного показа, говоря “Лучше один раз показать, чем 100 раз говорить”, а мать Алан-гуа на несколько веков раньше него придерживалась принципа “Лучше один раз дать выполнить самим, чем 100 раз показывать”, который на шаг продвигает идею И.А.Коменского и который сегодня мы начали почитать, уразумев на своём жизненном опыте.

В-третьих, видно, что мать Алан-гуа использовала принцип “Наглядности”, тем более принцип показа посредством позволения самим выполнить, который является одним из основных принципов современного обучения, направленного на глубокое овладение Знаниями простым, понятным способом. В-четвёртых, метод обучения посредством физического выполнения с опорой на осязание, о котором рассказывается в легенде, сегодня считается самым эффективным методом. Данный образ матери Алан-гуа, обучающей своих пятерых сыновей, является образом лучшего учителя или новым образом учителя, который мы сегодня усиленно ищем. Дело в том, что она, как говорилось выше, сумела создать самое благоприятное условие для обучения своих детей, доведения до них своих слов или сумела реализовать принцип обучения. Также выбрала самый благоприятный, эффективный метод обучения и рационально использовала выбранный метод. Таким образом полностью реализует свою цель обучения, воспитания, развития своих детей. Таким образом “Легенда о матери Алан-гуа”, с одной стороны, передает нам в наследство много принципов, методов обучения, которые были созданы Монголами и использовались много веков. Тому назад и которые не потеряли ценность и сегодня. Поэтому “Легенда о матери Алан-гуа” является источником монгольской народно-педагогической традиции.

ХIII зуунд зохиогдсон ‘Монголын нууц товчоо’-ны 3-22 зүйлд Алангуа эхийн домог байдаг. Энэ домогт ‘Харчугийн хөвүүн Боржигдай мэргэн бүлгээ. Боржигдай мэргэний гэргий нь Монголжин гуа, түүнээс төрсөн хөвүүн Торголжин баян. Торголжин баян, Борогчин гуа гэргийтэй, Боролдайсуялби гэдэг залуу зарцтай, дайр бор хоёр хүлэг морьтой бүлгээ. Торголжин баяны хөвүүн Дува сохор, Добу мэргэн хоёр бүлгээ.

Дува сохор магнай дундаа ганц нүдтэй гурван нүүдлийн газар харах бүлгээ. Нэгэн өдөр Дува сохор, Добу мэргэн дүүтэйгээ Бурхан халдун уулан дээр гарав. Дува сохор, Бурхан халдун дээрээс Түнхлэг горхин уруу нэгэн бүлэг иргэн нүүж айсуу.

Дува сохор өгүүлрүүн: “Тэр нүүдэл иргэний дотор тэрэгний мухлагийн өмнө нэг сайхан охин сууж явна. Хүний гэргий болоогүй бол Добу мэргэн дуу чамд гуйж гэргий болгоё” гээд түүнийг үзүүлэхээр

Добу мэргэн дүүгээ илгээв. Добу мэргэн, тэр нүүдэлд хүрч охиныг үзвэл үнэхээр алдартай, гоо сайхан охин бөгөөд хүний гэргий болоогүй ажээ. Нэр Алун-гуа гэнэ.

Энэ охин, хорь түмдийн ноён Хорилардай мэргэний гэргий Баргужин гуагаас хорь түмд (хорь буриад)-ийн нутаг Ариг ус гэдэг газар төржээ. Түүний эх Баргужин төхүмийн эзэн Баргудай мэргэний охин бүлгээ. Тэр бүлэг иргэн бол Хорилардай мэргэнийх ажээ.

Хорилардай мэргэн, хорь түмдийн газарт булга, хэрэм зэрэг ан гөрөөс агнахаа хориглон булаалдаж харилцан муудалцаад салж, хорилар овогтон болоод Бурхан халдун ууланд ан гөрөөс элбэг гэж сонсож, Бурхан халдуны эзэн бурхан босгосон Шинч баян урианхайтай уулзахаар нүүж ирсэн ажээ. Энэхүү хорь түмдийн ноён Хорилардай мэргэний охин, Ариг уснаа төрсөн Алунгуаг гуйж, Добу мэргэний гэргий болгосон ёс тийм ажээ.

Алунгуа, Добу мэргэнд ирээд Бүгүнүтэй, Бэлгэнүтэй гэдэг хоёр хөвүүнийг төрүүлэв.

Дува сохор ах нь Дөрвөн хөвүүнтэй бүлгээ. Дува сохорыг үхсэний хойно түүний дөрвөн хөвүүн, Добу мэргэнийг авга гэж үзэхгүй доромжилж салж нүүгээд Дөрвөд овогтон болов.

Түүний хойно нэг өдөр Добу мэргэн Тогоцог өндөр дээр гөрөөлөхөөр гарвал, ой дотор нэгэн урианхай хүн гунжин буга алаад хавирга цоройг шарж байхад уулзаж, “Нөхөр шоролгодоо” гэж Добу мэргэн хэлбэл, тэр хүн уушги зүлд ба арьсыг өөрөө авч, бусдыг цөм Добу мэргэнд өгөв.

Добу мэргэн, тэр бугын махыг ачиж явтал замд хүүхдээ хөтөлсөн нэгэн ядуу хүн учрав.

Тэр хүн өгүүлрүүн: “Би Малиг баяудын хүн. Одоо би ядарч явна. Тэр гөрөөсний махнаас надад өг. Би энэ хөвүүнээ чамд өгье” гэвэл, Добу мэргэн зөвшөөрч, бугын өрөөсөн гуяыг тэр хүнд өгөөд Хөвүүнийг авч ирж гэртээ зарцлах болов.

Тэгж байтал Добу мэргэн үгүй болов. Добу мэргэнийг үгүй болсны хойно түүний гэргий Алун-гуа бэлбэсэн бөгөөтөл Буха хатаги, Бухату салжи, Бодончар мунхаг гэдэг нэртэй гурван хөвүүнийг төрүүлэв.

Урьд Добу мэргэнийг амьд бүхий цагт төрсөн Бэлгэнүтэй, Бүгүнүтэй хоёр хөвүүн, эх Алунгуагаас

эчнээ хэлэлцсэн нь: “Бидний эх, ойр төрлийн эрэгтэй хүнгүй ба эргүй бөгөөтөл энэ гурван хөвүүнийг төрүүлэв. Гэр дотор ганц Малиг баяуд овгийн зарц хүн байна. Энэ гурван хөвүүн, түүний хүүхэд биз” гэж эхээс далд хэлэлцэхийг нь Алун-гуа мэдээд,

Хаврын нэгэн өдөр хонины хатсан мах чанаж Бэлгүнүтэй, Бүгүнүтэй, Буха хатаги, Бухату салжи, Бодончар мунхаг таван хөвүүндээ идүүлээд Тэднийг зэрэгцүүлэн суулгаж, хүн бүрд нэжээд мөс (сум буюу нарийн мод)-ийг хугал гэж өгвөл амархан хугачиж орхив. Бас таван мөсийг нийлүүлж баглаад хугал гэж өгвөл тавуулаа дараалан оролдож хугалж чадсангүй.

Үүнд Алун-гуа эх нь өгүүлрүүн: “Бэлгүнүтэй, Бүгүнүтэй та хоёр намайг энэ гурван хөвүүнийг яахин төрүүлэв, хэний хөвүүд бол гэж сэжиглэн хэлэлцэнэ. Сэжиглэх тань зөв.

Гэвч, та нар учрыг мэдэхгүй байна. Шөнө бүр цагаан шар хүн, гэрийн өрх тотгоор гийгүүлэн орж ирээд миний хэвлийг илэхэд түүний гэрэл миний хэвэлд шингэх бүлгээ. Тэр хүн, гарах нар сарны хилээр шар нохой мэт шарвалзсаар гарч одно. Дэмий яахин өгүүлнэ та. Түүнээс үзвэл тэнгэрийн хөвүүд биз. Хар тэргүүт хүнтэй адилгаж яахин болно. Хамгийн хаад болох цагт харц хүн сая учрыг мэднэ” гээд бас Алун-гуа, таван хөвүүнээ сургаж өгүүлрүүн: “Та таван хөвүүн, миний нэгэн хэвлэлээс төрсөн биш үү. Та нар ганц ганцаар салбал нэжээд сум мэт хүнд хялбархан дийлэгдэнэ. Та нар эе эвээ нэгтгэвэл тэр багласан таван сум мэт бат бэх болж, хэнд ч хялбар дийлэгдэхгүй болно” гэв [Монголын, 1990. 27-28-р тал] хэмээн өгүүлдэг.

Уг домгийг Чехословакийн эрдэмтэн Павел Поуха¹⁰, Зөвлөлтийн эрдэмтэн И.С.Лисевич¹¹, эрдэмтэн Ш.Гаадамба¹², Ц.Дамдинсүрэн¹³ нарын олон судлаачид анхааран судалж ирсэн байна. Эдгээрээс П.Поуха, И.С.Лисевич Ц.Дамдинсүрэн нар домгийн үүсэл гарлыг мөшгөсөн байна.

Ц.Дамдинсүрэн гуайн тэмдэглэснээр И.С.Лисевич Алан-гуа эхийн домгийг дэлхий дахинд дэлгэрсэн “тэнэмэл домог” агаад түгүүхүн, монгол хоёрт гаднаас сүүлд нэвтэрч ирсэн домог гэж үзэж байна. Энэхүү И.С.Лисевичийн дээрх домгийг дэлхий дахинд дэлгэрсэн “тэнэмэл домог” хэмээн үзсэнийг Ц.Дамдинсүрэн гуай дэмжсэн боловч “Түгүүхүн ба монголчуудын дотор энэ домог урьд байгаагүй, сүүлд

нэвтэрсэн гэдэг нь баримтгүй зөвхөн таамаглал” [Дамдинсүрэн, 1979. тал 84] гэж үзсэн байна.

И.С.Лисевич таван савааны домог нь анх манай он тооллоос хэдэн зуун жилийн өмнө бичигдсэн грекийн Эзопын шог үлгэрт ороод улмаар Дэлхий дахинд дэлгэрч Хятадад хүртэл нэвтэрсэн хэмээн таамаглажээ. Гэтэл Эзопын домог нь өмнөд европын нүүдэлчин Скиф аймгийн Домгоос гаралтай ба Хятад хэлээр VI зууны үед бичигдсэн Вэй улсын түүхэнд мөн домгийг түгүхүн аймгийн домог гэж заасан байна. Иймээс Ц.Дамдинсүрэн гуай таван сумны домог нь “... грек, хятад хэлээр хамгийн түрүүнд бичигдсэн боловч үүнийг мөн домгийн үүсэл гэж болохгүй. Грек, хятад хоёр хэлээр бичигдэхээс өмнө буюу түүний зэрэгцээгээр Өмнөд европ, Төв азийн олон ард түмний дотор өргөн дэлгэрч яригдсаар байсан хуучин домог бололтой. Грек хэлээр бичигдсэн бүрийг грекийн домог гэж болохгүй, тэрчлэн хятад хэлээр бичигдсэн бүрийг хятадын домог гэж болохгүй. Үлгэр домог нь бичигдэж дэлгэрэхээс гадна амаар дамжиж үлэмжхэн дэлгэрдэг билээ.

... Тэгэхлээр таван сумны домгийг түгүхүн ба монголчууд заавал бусдаас зээлдэж авсан байх учиргүй, өөрсдөө ч бүтээсэн байж болох билээ. Үүнээс гадна Вэй улс бол монгол угсааны табгаач нарын байгуулсан улс билээ. Монгол угсааны түгүхүн аймгийн домог, мөн монгол угсааны Вэй улсын түүхэнд орж бичигдсэн байхад үүнийг хятад хэлээр бичигдэж үлдсэнийг баримталж хятад домог мэтээр үзэж болохгүй [Дамдинсүрэн, 1979. тал 84-85] гэжээ. Улмаар Ц.Дамдинсүрэн хэдэн сум буюу саваагаар жишээ болгож эв найрамдалгүй Хөвгүүдээ сургасан домог дэлхий дахинд түгээмэл дэлгэрсэн агаад ийм домог “Нууц товчоо”-г бичигдэхээс хэдэн зуун жилийн өмнө олон монгол аймгуудын дотор дэлгэрсэн байсныг тэмдэглэсэн байна.

Энэхүү Алан-гуа эхийн домог нь эртний Монгол домог гэдэг саналыг бид ч бүрэн дүүрэн хуваалцахын зэрэгцээ уг домог нь Монгол ардын сурган хүмүүжүүлэх зүйн эх сурвалж болохыг онцлон тэмдэглэж байна.

Уг домгийг сурган хүмүүжүүлэх зүйн үүднээс ажиглан судалсан хүн бол эрдэмтэн Ш.Гаадамба юм. Гэхдээ тэрээр Алан гуа эхийн домгийг тусгайлан

судлаагүй бөгөөд харин “Нууц Товчоо”-нд тусгагдсан сурган хүмүүжүүлэх уламжлалыг судлах явцдаа домогт тусгагдсан ардын сурган хүмүүжүүлэх зүйн уламжлалт зарим арга зарчмын талаар тэмдэглэсэн байна.

Ш.Гаадамба Алан гуа эхийн таван хүүхдээ хойшид эв найрамдалтай байх талаар сургасан домгийг иш татаж ... дурдсан баримтаас үзвэл, нэгд “сүегэр үг өгүүлэх” гэдэг нэг ёс байжээ. Хоёрт, тэр сүегэр үг гэгчийг эцэг эх нь хүүхдэдээ хандаж хэлдэг байжээ. Иймд энэ бол өсвөр үеийг хүмүүжүүлэх нэг арга мөн байжээ. Гуравт, сүегэр үг өгүүлэхдээ юмыг холбогдох өөр баримт үзэгдэлтэй жишиж харьцуулан, учрыг аль болохоор ухамсарлуулан ятгадаг байжээ” [Гаадамба, 1990. Тал 206] хэмээн дүгнэжээ. Өөрөөр хэлбэл, уг домогт эртний монголчуудын сүегэр үг өгүүлэх буюу сургаж, суях арга зарчим байсныг ажиглан тэмдэглэсэн байна

Бидний ажигласнаар “Алан гуа эхийн домог”-т орчин үеийн сургалтын практикт хэрэглэж буй гурван үндсэн зарчим тусгагдсан байдаг. Үүнд:

Нэгд, Хавар цаг нүүдэлчдийн хувьд өвөл нөөцөлсөн хоол хүнс дууссан, мал тарга тэвээргээ алдсан, өдөр уртассан, хомс тарчиг үе байдаг. Ийм үе буюу хаврын нэгэн өдөр Алан гуа, өдрийн цагаар хонины хатсан мах чанаж, таван хөвүүндээ идүүлсэн нь санамсаргүй хэрэг биш байлаа. Тэрээр өөрийн сэтгэлийн үгээ хүүхдүүддээ хүргэх тааламжтай нөхцөл олсон нь тэр байв. Өөрөөр хэлбэл дээрх үйлийг үйлдсэнээрээ хүүхдүүддээ үгээ хүргэх сэтгэл зүйн таатай нөхцөлийг бүрдүүлж чадсан байна. Энэ нь хөвүүдээ хооллосны дараа түүний хийсэн үйлээр батлагддаг.

Тийнхүү орчин үеийн сургалтын үндсэн зарчмын нэг “сургалтын процесс явагдах тохиромжтой нөхцөлийг буй болгох” зарчим хангагдсан байна. Энэ тухай Ш.Гаадамба “Алан гуа монголчуудын хэлэлцдэгээр мах магнаг (ө. х маш ховор) болж, манай ээж шулам (ө. х. маш харамч) болж, ирдэг хаврын ховор зэвэр цагт үүцний тарган хонины мах чанаж өгч хүүхдүүдтэйгээ онцгой яриа ярилцах тодорхой нөхцөлийг бүрдүүлжээ” [Гаадамба, 1990, т. 206] гэсэн байна.

Хоёрт. Таван хөвүүнээ зэрэгцүүлэн суулгах хүн бүрд нэжээд сум (сум буюу нарийн мод)-ийг хугал гэж өгч амархан хугачуулсан ба бас таван

мөсийг нийлүүлж баглаад хугал гэж өгч тавуулангаар нь дараалуулан оролдуулж хугалуулж чадаагүй нь мөн санамсаргүй хэрэг биш бололтой. Учир нь хүнд сонсговол мартдаг, үзүүлбэл санадаг, хийлгэвэл сурдаг гэх дорно дахины сургалтын зарчмыг баримталж, тэднээр өөрсдөөр нь үйлдүүлэн, үйлдлээр нь дамжуулж сургах зарчмыг баримталсан аж. Ингэснээр Алан гуа эхийн сургаал хөвүүдэд хийгээд хойч үеийнхэнд билиг болон хоногшжээ.

Бүр XVII зуунд агуу их сурган хүмүүжүүлэгч Я.А.Коменский хоосон номлож, амаар мэдээлэл дамжуулах сургалт маш бага үр дүнтэй болохыг тэмдэглээд <<Зуу дахин сонсгосноос нэг удаа үзүүл>> гэж түүнийг үзүүлэн таниулах сургалтаар солих санааг дэвшүүлж [Ванчигсүрэн, Дорж., 1992. тал 17-18] байсан бол түүнээс хэдэн зуун жилийн өмнө Алан гуа эх, Я.А.Коменскийн үзэл санаанаас, нэг алхам ахисан зуун удаа үзүүлснээс, нэг удаа хийлгэж гүйцэтгүүлэх нь дээр гэсэн өнөөгийн бидний амьдралынхаа туршлагаар ухаарч, шүтэж эхлээд буй арга, зарчмыг баримталж байжээ.

Гуравт. Алангуа эх, мэдлэгийг хялбар дөхөм, ойлгомжтой, гүн бат эзэмшүүлэх зорилго бүхий орчин үеийн сургалтын үндсэн зарчмын нэг “үзүүлэн таниулах” зарчмыг, тэр тусмаа өөрөөр нь үйлдүүлэн үзүүлэх зарчмыг хэрэглэсэн нь харагдаж байна. Энэ тухай Гаадамба “... Нэг мод, багц мод хугалуулж нэг маягийн угтвар <<туршлага>> хийлгэж энэ

<<үзүүлэн таниулахад>> түшиглэн үнэмшилтэй, (баримттайгаар) сургамжлан ятгасан нь тэмдэглүүштэй” [Гаадамба, 1990. Т.206] гэжээ.

Дөрөвт. Домогт өгүүлэгдэж байгаа хүртэх мэдрэхүйд нь тулгуурлан биетээр үйлдүүлж сургах арга нь өнөөдөр хамгийн үр дүнтэй аргад тооцогдож байна. Энэхүү Алан гуа эхийн таван хүүхдээ сургаж буй дүр бол өнөөдөр бидний эрж сураад буй шилдэг багшийн дүр буюу багшийн шинэ загвар юм. Учир нь тэрээр дээр өгүүлснээр хүүхдээ сургах, тэдэнд өөрийн үгээ хүргэх хамгийн тохиромжтой нөхцөлийг бий болгох буюу сургалтын зарчмаа хэрэгжүүлж чадаж байна. Улмаар сургалт явуулах хамгийн тохиромжтой, үр дүнтэй аргыг сонгон авч, сонгосон аргаа оновчтой хэрэглэж байна. Ингэснээрээ хүүхдүүдээ сургах, хүмүүжүүлэх, хөгжүүлэх зорилгоо бүрэн дүүрэн хангаж байна. Ийнхүү Алангуа эхийн домог нэг талаар монголчуудын олон зууны тэртээ бүтээн хэрэглэж ирсэн агаад өнөөдөр ч үнэ цэнэтэй сургалтын олон зарчим, аргыг бидэнд өвлүүлж байна. Иймд Алан-гуа эхийн домог бол монгол ардын сурган хүмүүжүүлэх зүйн эх сурвалж мөн.

Нөгөө талаар уг домог бидэнд өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнуудын сургалтын онол, практикаас суралцахын зэрэгцээ өвгөдөөсөө, өвөөсөө суралцах зүйл их буйг сануулж байна.

Номзүй

1. [Монголын, 1990]- Монголын нууц товчоо УБ., 1990.
2. (Дамдинсүрэн, 1979) - Ц.Дамдинсүрэн Алан гуагийн таван хөвгүүдээ сургасан Домог. *Studia Mongolica Tomus VII (15). Fasc 7, UB., 1982.*
3. [Гаадамба, 1990) - Ш.Гаадамба Сурган хүмүүжүүлэх уламжлал “Нууц товчоо”-нд тусгагдсан нь. Монголын нууц товчооны судлалын зарим асуудал УБ., 1990 тал. 205-212.
4. (Ванчигсүрэн, Дорж., 1992)-Д.Ванчигсүрэн, Ц.Дорж Сургалтын технологи УБ., 1992.
5. [Гаадамба, 1990) - Ш.Гаадамба Сурган хүмүүжүүлэх уламжлал “Нууц товчоо”-нд тусгагдсан нь. Монголын нууц товчооны судлалын зарим асуудал УБ., 1990 тал. 205-212.
6. Мөн тэнд., тал 206.